Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2020 оны 02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

Д/Д	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	МЭДЭЭЛЭЛ
1.	**Нэр** Овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Базар овгийн Даньхүүгийн Баянбилэг
2.	**Хүсэлт гаргагчийн хаяг** Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	Улаанбаатар хот
3.	**Төрсөн огноо** Төрсөн газар	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар төрөх газар
4.	**Боловсрол** Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг хамгийн сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, эзэмшсэн зэрэг, диплом олгогдсон огноог бичнэ.	1/ Хилийн цэргийн дээд сургууль, 2006.10 - 2008.05 /1.5 жил/, Магистрын зэрэг, Диплом №Е20081095. 2/ Отгонтэнгэр дээд сургууль, 1996.10 - 1998.10 /2 жил/, Бакалавр, Эрх зүйч, Диплом №9805236. 3/ Монгол Улсын Их сургууль, Аспирантур, 1997.10 - 2001.10 /4 жил/ 4/ Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт, 1995.09 - 1996.06 /1 жил/, Төрийн удирдлага, арга зүй, зохион байгуулалт, Диплом №613. /Дипломын дараах сургалт/ 5/ НАХЯ-ны Цэргийн дээд сургууль, 1984.07 - 1989.06 /5 жил/, Нийгмийн ухаан – улс төр, Диплом №00471.
5.	**Ажил эрхлэлт** Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	1/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, Тамгын газрын дарга, 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш /Ажил олгогч: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга асан Ж.Амарсанаа/ 2/ “Мэргэн Их Монгол” ХХК, Захирал /Үүсгэн байгуулагч/, 2010.01.10 - 2014.07.01 3/ Хууль зүйн үндэсний төв, Хууль зүйн мэдээллийн төвийн дарга, 2002.11.29 - 2009.05.06 /Ажил олгогч: Хууль зүйн үндэсний төвийн захирал асан Ж.Амарсанаа/. 4/ Оюуны өмчийн сан /ХЗЯ-ны харьяанд/, Захирал, 1998.10.01 - 2002.12.01 /Ажил олгогч: Төлөөлөн удирдах зөвлөл, Ж.Амарсанаа/.

		5/ “Монголын хүний эрхийн төв” ТББ, Гүйцэтгэх захирал, 1998.10.01 - 2002.12.01 /Ажил олгогч: Монгол хүний эрхийн төвийн Ерөнхийлөгч Ж.Амарсанаа/. 6/ Хууль зүйн яам, Сайдын туслах, 1996.08.08 - 1998.06.17 /Ажил олгогч: Хууль зүйн сайд асан Ж.Амарсанаа/. 7/ “Харгуй” ХЭАА, Менежер /Үүсгэн байгуулагч/, 1992.01.17 - 1995.08.31 8/ Хилийн цэргийн отрядын застав, Улс төрийн орлогч, 1989.07.17 – 1991.07.02, /Ажил олгогч: Нийгмийг аюулаас хамгаалах яам, Орлогч сайд/ 9/ НАХЯ-ны Цэргийн дээд сургуулийн сонсогч, 1984.07.25 – 1989.06.30, /Ажил олгогч: Нийгмийг аюулаас хамгаалах яам, Сайд/
6.	**Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал** Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, эсхүл Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаагаа талаар бичнэ.	Монгол Улсын иргэн Д.Баянбилэг би Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших хүсэлт гаргаж байна.
7.	**Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил** Хүсэлт гаргагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: - албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; - ажлын байрны тодорхойлолт; - удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.	1/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, Тамгын газрын дарга, 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш. /Удирдах албан тушаалтан: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга асан Ж.Амарсанаа/ <u>Албан тушаалын тодорхойлолт:</u> Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, Үндсэн хуулийн цэц бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Тамгын газрын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах. Хамт ажилласан хүний мэдээлэл: - Г.Даваадалай; - Н.Болортунгалаг; - Н.Соронзонболд; - Р.Мухийт; - Б.Дуламсүрэн. 2/ Хууль зүйн үндэсний төв, Хууль зүйн мэдээллийн төвийн дарга, 2002 – 2009 он. /Удирдах албан тушаалтан: Хууль зүйн үндэсний төвийн захирал асан Ж.Амарсанаа/ <u>Албан тушаалын тодорхойлолт:</u> Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны ажлыг хуульд нийцүүлж бүхий л арга, хэлбэрээр нийтэд зориулан зохион байгуулах.

		Хамт ажилласан хүний мэдээлэл: - Б.Чимид; - Ж.Энхнасан; - Т.Мэндсайхан; - Ц.Түвшинзаяа; - Б.Дашдулам. 3/ “Монгол хүний эрхийн төв” ТББ, Захирал, 1998 – 2002 он. Удирдах албан тушаалтан: Монголын хүний эрхийн төвийн Ерөнхийлөгч Ж.Амарсанаа. Албан тушаалын тодорхойлолт: Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах. Хамт ажилласан хүний мэдээлэл: - М.Мөнхбат; - Б.Амарсанаа; - М.Уянга; - А.Аюурзана; - Э.Байгаль.
8.	**Ёс зүй** Доор дурдсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно. - сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх; - сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх.	- Үгүй. Хууль бус захиргааны актаар сахилгын шийтгэл ногдуулсныг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2026.09.11-ний өдөр хуралдаж, шинээр захиргааны акт гарах хүртэл 3 /гурав/ сарын хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд гаргаагүй бол захиргааны акт /тушаал/ хүчингүй болох Шийдвэр гаргасан (Шийдвэр нь нууцын зэрэглэлтэй). Захиргааны хэргийн давж заалдах шатны 2026 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хуралдаж, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр тогтоосон Магадлал гаргасан (Магадлал нь нууцын зэрэглэлтэй). - Үгүй.
9.	**Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар** Хүсэлт гаргагчийн хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: - үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; - үйл ажиллагааны гол агуулга; - үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; - үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан	1/ 2014 оны 07 дугаар сараас хойш Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Тамгын газраас мэргэжил, арга зүй, зохион байгуулалт, санхүү, аж ахуйн бүх дэмжлэгийг үзүүлэхэд хууль тогтоомж, эрх зүйн бусад актын дагуу удирдан зохион байгуулсан. 2/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлагийн хооронд байгуулсан гэрээгээр “Үндсэн хуулийн шүүхийн шинэтгэл ба ардчилал,

	таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; - хэвлэгдсэн бол эх сурвалжийн эшлэл, түүний хуулбар.	хүний эрх” төслийг 2024-2026 онд амжилттай хэрэгжүүлсэн. 3/ “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл” /1992-2025 он/-ийг анх удаа бүрэн 6 ботиор 2025, 2026 онд эрхлэн гаргах ажлыг зохион байгуулав. 4/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2021-2023 онд Үндсэн хуулийн шүүх болон түүнтэй адилтгах байгууллагуудын Азийн нийгэмлэгийг даргалсан. Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат тус нийгэмлэгийн Ерөнхийлөгчийн, Тамгын газрын дарга тус нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн даргын албан үүргийг хоёр жилийн хугацаанд амжилттай гүйцэтгэсэн. Монгол Улсын гадаад харилцааг хөгжүүлэх, бэхжүүлэхэд өндөр үр дүнтэй, ач холбогдол бүхий амжилт гаргасан. 5/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхий нарийн бичгийн даргын газар, КОЙКА байгууллагатай хамтран “Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг цахимжуулах нь” төслийг 2018-2020 онд амжилттай хэрэгжүүлсэн. 6/ Монгол Улсын нийт айл - өрх гэрт зориулсан хууль зүйн зөвлөгөө мэдээллийн “Өрхийн эрх зүйн хөтөч” нэртэй гарын авлагыг 36 үндсэн сэдэв, 150 орчим дэд сэдвээр 2018 онд бүтээгдэж, хэвлэгдэж, олон нийтийн хүртээл болоход анхлан 33 зохиогч нарт зөвлөж, төслийг нэгтгэн хянан тохиолдуулсан. 7/ “Монгол Улсын хууль” төслийн хүрээнд өргөн хүрээтэй судалгаа хийж, “Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл” цувралыг 1206 оноос хойш 804 жилийн хугацаанд үйлчилж, хэрэгжиж байсан, одоо ч хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгийг тайлбарлан таниулах, иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх, эрх зүйн соёлыг дээшлүүлэх, Монгол Улсын төрт ёс, түүх, соёлын уламжлалыг гадаадын улс орнуудад таниулах, сурталчлах зорилтоор 2010 онд 16 ботиор эмхтгэн гаргасан, одоо Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс үргэлжлүүлсээр 26 боть болгосон байна. 8/ Монгол Улсын дээд шүүх, Хууль зүйн үндэсний төв, холбогдох олон улсын байгууллагуудтай хамтарсан төслийн хүрээнд 2005-2008 онд Монгол Улсын шүүхийн шийдвэрүүдийг анх удаа сонгон төрөлжүүлэн, эмхтгэх ажлыг зохион байгуулалцаж, “Монгол Улсын шүүхийн шийдвэр: Эрүүгийн хэрэг”-ийн 4 боть, “Монгол Улсын

		шүүхийн шийдвэр: Иргэний хэрэг”-ийн 7 боть, “Монгол Улсын шүүхийн шийдвэр: Захиргааны хэрэг”-ийн 1 ботийг тус тус эрхлэн гаргахад оролцсон. Энэ нь шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах нэгэн илэрхийлэл болж, шүүхийн онол, практик судлалыг хөгжүүлэх бүтээл, шүүгч, хууль зүйн сургуулийн багш, оюутан нарт анхны гарын авлага болсон юм. 9/ Хууль зүйн үндэсний төв /Одоогийн Хууль зүйн үндэсний хүрээлэн/-өөс шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульч нар, хууль зүйн сургуулийн оюутнууд, иргэдийн мэдэх эрхийг хангах, мэдлэгийг дээшлүүлэх, үйлчилгээ үзүүлэх зорилтоор өөрийн хариуцаж байсан Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны төвийн үйл ажиллагаа дараах чиглэлд ажиллаж байв. Тухайлбал, *legalinfo.mn* цахим эрх зүйн мэдээллийн системийг, хэвлэх үйлдвэр, “Есөн туг” телестуди, “Хууль зүйн мэдээ сонин”, “Хууль зүйн мэдээлэл”, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, Номын сан, Компьютерийн лабораторийг үүсгэн бий болгож ажиллалаа. 2002-2009 оны хооронд Хууль зүйн үндэсний төвийн 14 хоног тутмын “Хууль зүйн мэдээ” сониныг, 14 хоног тутмын “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүл, мөн улирал тутмын “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийг эрхлэн гаргах, түүнчлэн ном, гарын авлагыг давхардсан тоогоор 250 гаруй нэр төрлөөр, СД 27 нэр төрлөөр, тус бүр 25-30 минут үргэлжлэх “Хуулийн цаг” телевизийн нэвтрүүлгийн 83 цувралыг бүтээх, нийтэд түгээх, мэдээллэх ажлыг удирдан зохион байгуулж ажилласан болно. 10/ дээр дурдсанаас гадна дангаараа болон бусадтай хамтран 27 номыг бүтээлцэж, 29 номыг хянан тохиолдуулж, 12 удаа илтгэл тавьж, 11 өгүүллийг нийтлүүлж, 14 судалгааны ажилд оролцсон байна.
10.	**Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил** Хүсэлт гаргагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: - албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; - ажлын байрны тодорхойлолт; - удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.	1/ Монгол Улсын Хүний эрхийн Үндсэний Комиссын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт Үндсэн хуулийн цэц багтдаг. Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын даргаар 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр томилогдсоноос хойш Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Тамгын газраас мэргэжил, арга зүй,

		зохион байгуулалт, санхүү, аж ахуйн бүх дэмжлэгийг үзүүлэхэд хууль тогтоомж, эрх зүйн бусад актын дагуу удирдан зохион байгуулсан. Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, сургах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллав. /Удирдах албан тушаалтан: Үндсэн хуулийн цэцийн дарга асан Ж.Амарсанаа/ Хамт ажилласан хүний мэдээлэл: - Г.Даваадалай; - Н.Болортунгалаг; - Н.Соронзонболд; - Р.Мухийт; - Б.Дуламсүрэн. 2/ “Монгол хүний эрхийн төв” ТББ, Гүйцэтгэх захирал, 1998 - 2002 он. /Удирдах албан тушаалтан: Монголын хүний эрхийн төвийн Ерөнхийлөгч Ж.Амарсанаа/ <u>Албан тушаалын тодорхойлолт:</u> Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах. <u>Хамт ажилласан хүний мэдээлэл:</u> - М.Мөнхбат; - Б.Амарсанаа; - М.Уянга; - Аюурзана; - Э.Байгаль. 3/ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн гишүүнээр 2002-2004 он, 2004-2007 онд тус тус хоёр удаа томилогдож, нийт таван /5/ жилийн хугацаагаар ажилласан. /Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын тушаал 2002.03.04, Дугаар 06; 2004.04.09, Дугаар 05/
11.	**Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал** Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: - үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; - үйл ажиллагааны гол агуулга; - үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;	1/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Тамгын газраас хүний эрхийн талаархи хууль тогтоомжид зааснаар иргэдэд төрийн үйлчилгээг ялгаварлалгүй, тэгш, хүртээмжтэй үзүүлэх, хүргэх үйл ажиллагааг байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн. 2/ ГТХАН /GTZ/-ийн ХЗДХЯ-д хэрэгжүүлж буй төслийн санаачилсан иргэдийг гэмт хэрэг, зөрчил, аюул ослоос урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах,

	- үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; - хэвлэгдсэн бол эх сурвалжийн эшлэл, түүний хуулбар	хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх чиглэлээрх “Хуулийн цаг” телевизийн 83 цувралыг бүтээх, олон нийтэд хүргэх, түгээх ажлыг 2006-2009 онд хамтран зохион байгуулалцсан. 3/ Хүний эрхтэй шууд холбогдолтой 6 номыг бүтээхэд оролцож, 5 номыг хянан тохиолдуулж, эрдэм шинжилгээний болон бусад хуралд 7 илтгэл хэлэлцүүлж, 8 өгүүллийг сэтгүүл, сонинд нийтлүүлж, томоохон 6 судалгаанд оролцсон байна. 4/ “Хүний эрхийг хөхиүлэн дэмжигч сонин”-г сонгон шалгаруулж алдаршуулах санаачилга гаргасан. “Өдрийн сонин” 2002 онд шалгарч анх энэ алдрыг хүртэж байсан. 5/ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн гишүүнээр томилогдон төлөвлөгөө гарган ажиллаж байх хугацаанд хүний эрхийн талаархи нийтлэг хууль тогтоомжийг судлах, сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх хэсгийг ахлан ажиллсан. Мөг Комиссын ажлын албаны ажилтнуудыг чадавхжуулах талаар зөвлөгөө өгч байв. 6/ Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр хамтран “Хүний эрхийн үндэсний хөтөлбөр” боловсруулах дэд төслийг хэрэгжүүлэх хүрээнд 2001 онд “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын судалгаа”-ны Онол, арга зүйн багийн гишүүнээр ажилласан. Нийт судалгааны баримтыг нэгтгэн, цэгцэлж, ном болгоход голлон ажилласан. 7/ Монгол Улсад 2000 оны 8 дугаар сарын 8, 9-ний өдөр НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар, хатагтай Мэри Робинсон айлчлах үеэр хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн байгууллагуудыг төлөөлж “Монголын хүний эрхийн төв” ТББ-ын удирдлагууд Хүний эрхийн үндэсний байгуулагын тухай хууль, ийм байгууллагыг байгуулах, үүнд дотоодын болон олон улсын байгууллагын хамтын ажиллагаа, дэмжлэгийн талаар ярилцлага-уулзалт хийсэн. ЭНэ нь тус байгууллагын хууль батлагдах, үүсч, бэхжихэд хувь нэмэр оруулсан. 8/ Монгол Улсын Хүний эрхийн Үндсэний Комиссын тухай хуулийн төсөлд 20 багц санал өгч энэ нь хууль батлагдахад тусгалаа олсон. 9/Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийн сонсогч нарт 1997 онд “Хүний эрх” сонгон суралцах

		хичээлийг түр хугацаагаар заасан. 10/ Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтэд 1995-1996 онд суралцаж төгсөхдөө “Хүний эрх”-ийн хичээлд сонгон суралцаж “Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо” сэдвээр дипломын ажил бичиж хамгаалсан. /Удирдах албан тушаалтан: “Монгол хүний эрх төв” ТББ-ын Ерөнхийлөгч Ж.Амарсанаа/ <u>Хамт ажилласан хүний мэдээлэл:</u> - М.Мөнхбат; - Б.Амарсанаа; - М.Уянга; - Г.Даваадалай; - Н.Соронзонболд.
12.	**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар** Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: - албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; - ажлын байрны тодорхойлолт; - удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; - хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл **Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.**	**-**
13.	**Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар** Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ. - Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана. - Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ.	1/ Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн /Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 2003 он, Дугаар 458/ - Хууль зүйн үндэсний төвийн Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны төвийн даргын эрхлэх ажлын ачаалал өндөр байсан тул гишүүнчлэлийг дуусгавар болгосон. 2/ Монголын хуульчдын холбооны гишүүн /Гэрчилгээ: 2004.09.28 №004045, 2006.09.04 №0000162, 2015.01.29 №4677/ - Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа тул түдгэлзүүлсэн. 3/ “Сүлдэт багана хилчдийн холбоо” ТББ-ын гишүүн /2016 оноос хойш/
14.	**Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл** - Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг,	**<u>Нэг. ХАМТРАН БОЛОН ДАНГААРАА БҮТЭЭСЭН НОМ</u>** 1. “Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах, гадаадын

	хэвлэсэн газар, огноог бичнэ. - Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлтгэсэн, эсхүл бэлтгэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулыг бичнэ. - лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ. - Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө. **Жич: Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана.**	иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөхтэй холбогдсон асуулт-хариулт”, УБ., 2000 он, Хамтын бүтээл. 2. “Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах, гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөхтэй холбогдсон Монгол Улсын хуулиудын эмхтгэл”, УБ., 2000 он, Хамтын бүтээл. 3. “Хүний болон иргэний эрхтэй холбогдолтой Монгол Улсын хууль /Түүвэр/”, УБ., 2001 он, Хамтын бүтээл. 4. “Хүүхдийн эрхийн талаархи Монгол Улсын хууль /түүвэр/”, УБ., 2001 он, Хамтын бүтээл. 5. “Эвлэпдэн нэгдэх эрх /Хуулийн түүвэр/”, УБ., 2001 он, Хамтын бүтээл. 6. “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал”, УБ., 2001 он, Хамтын бүтээл. 7. “Гэрээ /Үлгэрчилсэн загвар/”, УБ., 2002, 2005, 2008, 2009 он, Хамтын бүтээл. 8. “Олон улсын эрүүгийн шүүх /Асуулт, хариулт/”, УБ., 2002 он, Хамтын бүтээл. 9. “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн”, УБ, 2004 он, Хамтын бүтээл. 10. “Захиргааны хэргийн шүүх”, УБ., 2004 он, Хамтын бүтээл. 11. “Хуульчдын сорилын хураамж”, УБ., 2004, 2005, 2006, 2007, 2008, 2009 он, Хамтын бүтээл. 12. “Газар, удирдлага, эрх зүй”, УБ., 2005 он, Хамтын бүтээл. 13. “Захиргааны хэргийн шүүх: Төр ба хүний эрх”, УБ., 2007 он. 14. “**Монгол Улсын хууль** (**4 боть**)”, УБ., 2008 он, Хамтын бүтээл. 15. “**Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл: 1206-2009 он** (**16 боть**)”, УБ., 2010 он, Хамтын бүтээл. 16. “Үндсэн хуулийн үгсийн чуулган”, УБ., 2011, 2012 он, Хамтын бүтээл. 17. “Хөдөлмөрийн харилцаа: Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл”, УБ., 2011, 2012, 2013, 2014 он, Хамтын бүтээл. 18. “Монгол Улсын Үндсэн хууль /1921*, 1924, 1940, 1960, 1990*, 1992 он/”, УБ., 2012 он, Хамтын бүтээл. 19. “Шүүх эрх мэдэл: Албан ёсны тайлбартай хуулийн эмхтгэл”, УБ., 2012 он, Хамтын бүтээл. 20. “Эрүүгийн хэрэг: Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл” УБ., 2012, 2013 он, Хамтын бүтээл. 21. “Захиргааны хэрэг: Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл” УБ., 2013 он, Хамтын бүтээл. 22. “Иргэний хэрэг: Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл” УБ., 2013 он, Хамтын бүтээл.

23. “Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл – Шүүх эрх мэдэл (монгол-англи хэлээр)”, УБ., 2013 он, Хамтын бүтээл.
24. “Монгол үндэстний бүрэн түүх” (Үүсмэл бүтээл) I, II дэвтэр, УБ., 2013 он, Хамтын бүтээл.
25. “Процессын эрх зүйн толь” УБ., 2013 он, Хамтын бүтээл.
26. “Процессын эрх зүй: Онол, туршлага” УБ., 2014 он, Хамтын бүтээл.
27. “Үндсэн хуульт ёс: Дээж бичиг” УБ., 2023 он, Хамтын бүтээл

<u>Хоёр. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН НОМ</u>

1. Ж.Амарсанаа, “Хүүхдийн эрхийн нэр томьёоны товч тайлбар толь”, УБ., 2001 он.
2. Виктор Конде, “Хүний эрхийн олон улсын нэр томьёоны гарын авлага”, /орчуулга/, УБ., 2002 он.
3. “Өмгөөлөл /Баримт бичиг/”, УБ., 2002 он.
4. “Татвар: Эрх зүйн баримт бичиг”, УБ., 2003 он.
5. “Газар: Эрх зүйн баримт бичиг”, УБ., 2003 он.
6. “Хуулийн нэр томьёоны дагалга”, УБ., 2004 он.
7. “Гадаад харилцаа /Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл/”, УБ., 2004, 2011 он.
8. “Өмгөөлөлтэй холбогдсон 100 асуулт, хариулт”, УБ., 2005 он.
9. “Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм /зурагт тайлбартай/”, УБ., 2005, 2007, 2009 он.
10. “Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн эмхтгэл /Иргэний хэрэг/” цуврал 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар боть, УБ., 2005, 2006, 2007, 2008 он.
11. “Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн эмхтгэл /Эрүүгийн хэрэг/” цуврал 1, 2, 3, 4 дүгээр боть, УБ., 2006 он.
12. “Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн эмхтгэл /Захиргааны хэрэг/” цуврал 2 дугаар боть, УБ., 2005 он.
13. “Хүүхэд ба хууль ёс”, УБ., 2008 он.
14. **“Монгол Улсын хууль** (**4 боть**)”, УБ., 2008 он.
15. “Хорих байгууллагын нийгмийн ажил”, УБ., 2009 он.
16. **“Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл 1206-2009 он** (**16 боть**)”, УБ., 2010 он.
17. **“Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар”,** ГТХАН (GTZ), УБ., 2010, 2015, 2018, 2022, 2024 он, (Үүсмэл бүтээл, техникийн дахин хяналт).
18. Ж.Амарсанаа, “Монгол Улсын Үндсэн хуулийн маргаан, УБ., 2012 он.
19. Юрий Скуратов, “Владын амийг хэн егүүтгэв?” /орчуулга/, УБ., 2013 он.
20. Ханнс Кельзен, “Хэм хэмжээний тухай ерөнхий онол”

		/орчуулга/, УБ., 2013 он. 21.Ж.Амарсанаа, О.Батсайхан нар, “Монгол Улсын Засгийн газар (Түүхэн товчоон, 1911-2012)”, УБ., 2013 он. 22.Ж.Амарсанаа, Ц.Энхжин, “Монгол Улсын төрийн бэлгэ тэмдэг”, УБ., 2013 он. 23.Ж.Амарсанаа, “Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг”, УБ., 2013 он. 24.“Процессын эрх зүйн толь”, УБ., 2013 он. 25.“Процессын эрх зүй: Онол, туршлага”, УБ., 2014 он. 26.Арне Мавчич, “Үндсэн хуулийн хяналт” /орчуулга/, УБ., 2014 он (техникийн хяналт). 27.“Өрхийн эрх зүйн хөтөч”, ХЗДХЯ, ХЗҮХ, ГОУХН (GIZ), УБ., 2018 он. 28.Ж.Шишмишиг, “Үндэсний аюулгүй байдал: Эрх зүйн зохицуулалт”, УБ., 2024 он. 29.“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл, 1992-2024 он” 6 боть, УБ., 2025 он. **<u>Гурав. ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ИЛТГЭЛ</u>** 1. Европын омбудсман /”Хүний эрхийг хангах механизм” сэдэвт семинар, Улаанбаатар, 1999 он/. 2. Монгол Улсын оюуны өмчийн талаархи хууль тогтоомж (Intellectual Property Legislation of Mongolia) /“Аж үйлдвэрийн өмчийн эрх” олон улсын семинар, Япон, Токио, 1999 он/. 3. Хүний эрх-хэвлэл мэдээлэл. /”Зориг” сангаас зохион байгуулсан "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө" сэдэвт уулзалт-ярилцлага, 2000 он/. 4. Монгол Улсад хүний эрхийг хангахад төрийн бус байгууллагын үүрэг /”Хүний эрхийн олон улсын өдөр, Монгол Улсын Үндсэн хуулийн 10-н жилийн ойд зориулсан бага хурал”, 2001 он/. 5. Халдашгүй эрх /”Хүний эрхийн төлөө” төрийн бус байгууллагуудын анхдугаар чуулган, 2002 он/. 6. Захиргааны эрх зүйн шинэтгэл ба хүний эрх /”Төрийн захиргааны шинэтгэл-Захиргааны эрх зүй” семинар, 2002 он/. 7. Монгол Улсад хүний эрхийг хангахад төрийн бус байгууллагуудын үүрэг, оролцоо /”Орон нутгийн удирдлага дахь хүний эрхийг хамгаалах үүсгэл санаачилгын бүтцүүд: Ажлын эхлэл” семинар, 2002 он, ХЭҮК/. 8. Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа ба терроризмын эсрэг тэмцэл /”Терроризмын эсрэг” Олон улсын бага хурал, УБ., 2002 он/. 9. Бизнесийн холбогдолтой хууль тогтоомжийн өнөөгийн байдал /Хойд Америк, Монголын бизнесийн зөвлөл (NAMBC)-ийн

		Хөрөнгө оруулагчдын 7 дахь удаагийн бага хурал, 2004 он/ 10. Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа /“Хууль тогтоомжийн системчлэл ба эрх зүйн мэдээллийн асуудал” сургалт-семинар, 2005 он/. 11. Хүний аюулгүй байдлыг хангах нь: Хүний эрхийг зарлан тунхаглахаас хүний аюулгүй байдлыг хангах хүртэл /”Аюулгүй байдлын салбарын шинэчлэл ба хүний аюулгүй байдлыг хангах нь”, Олон улсын бага хурал, 2007 он, хамтарсан илтгэл/. 12. Монгол Улсын эрх зүйн мэдээлэл ба удирдлага /”Хууль тогтоох ажиллагаа ба өнөөгийн байдал“ Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын хууль зүйн эрдэм шинжилгээний бага хурал, 2008.6.10./. **<u>Дөрөв. НИЙТЛҮҮЛСЭН ӨГҮҮЛЭЛ</u>** 1. “Intellectual Property Legislation of Mongolia and Practice at Present Time” /”Patent” magazine. Токуо, Japan, 2000. №7 Vol.53, p.65-69/. 2. “The Constitution of Mongolia and Human Rights” /”Nomadic” monthly newsletter, Ulaanbaatar, 2002, No.30, p.3/. 3. “Гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хүний эрхийг хамгаалах хууль зүйн баталгаа” /”Монголын төр, эрх зүй” сэтгүүл, 2001 он, №4, 10-15 дахь тал/. 4. “Захиргааны албадлагын арга хэмжээ хэрэглэх явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зарим арга зам” /“Эрх зүй” сэтгүүл, 2001 он, №6-7, 81-84 дэх тал/. 5. “Монгол Улсын Үндсэн хууль ба хүний эрх” /”Эрх зүй” сэтгүүл, 2002 он, №8-9, 64-68 дахь тал/. 6. “Халдашгүй эрх” /”Хүний эрх” сэтгүүл, 2002 он, №2, 11-14 дэх тал/. 7. “Хууль зүйн нэр томьёоны талаархи зарим асуудал” /”Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2004 он, №3 (5), 11-16 дахь тал/. 8. “Personal inviolable rights” /First National Human Rights NGO’S Forum Papers, May 2-38, Ulaanbaatar, 2002, p.24-27/ 9. “Хүний эрх: Монгол Улсын Үндсэн хууль ба Захиргааны хэргийн шүүхээс эрх зүйн баримт бичгийг хэрэглэх зарим асуудал” /”Хүний эрх” сэтгүүл, 2005 он, №3, 16-23 дахь тал/. 10. “Хүний эрх, эрх чөлөө ба хүний хөгжил, хүний аюулгүй байдлын харилцан хамаарал” /”Хүний эрх” сэтгүүл, 2009 он, №2; 9-19 дэх тал; 2011 он, №2, 85-92 дахь тал/. 11. “Human security: From Declaration of Human Rights to Controlling Human security” /The Mongolian Journal of Strategic Studies, 2008, №2, p.105-115/.

		12. “Монгол Улсын хууль зүйн мэдээлэл ба удирдлага” /БНСУ, Монгол Улсын хоорондын хууль зүйн онол – практикийн бага хурал: Арга ажиллагаа ба өнөөгийн байдал, 2008.06.10, Улаанбаа-тар, 307-336 дахь тал/ 13. “Хууль зүйн нэр томьёоны талаар товчхон” /”Үндсэн хуульт ёс” сэтгүүл, 2025 он, №2, 46-52 дахь тал/. **Тав. ЗОХИОН БАЙГУУЛЖ, БҮТЭЭЛЦСЭН БАРИМТАТ КИНО** 1. “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц”, 2020 он, 9 минут 43 секунд. 2. “Алганд багтсан эх орон” Монгол Улсын Үндсэн хуулийн цуврал нэвтрүүлэг: “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц”, 2020 он, Үргэлжлэх хугацаа: 28 минут 15 секунд. 3. “Монгол Уулсын Үндсэн хуулийн хөгжлийн товчоон”, 2021 он, Үргэлжлэх хугацаа: 29 минут 27 секунд. 4. “Монголын ард түмний төлөөх Монгол Улсын Үндсэн хуулийн цэц”, 2022 он, Үргэлжлэх хугацаа: 11 минут 58 секунд. **Зургаа. СУДАЛГААНЫ АЖИЛД ОРОЛЦСОН БАЙДАЛ** 1. ”Монгол Улсад хүний эрхийг хангах асуудал” төсөл, судалгааны ажил (Монгол Улсын Засгийн газрын захиалга, 1999-2000 он). 2. ”Олон улсын эрх зүйтэй үндэсний хууль тогтоомжийг харьцуулах зарим асуудал” төсөл, судалгааны ажил (Монгол Улсын Засгийн газрын захиалга, 1999-2000 он). 3. “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал” судалгааны ажил (Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, ХЭҮК-ын хамтарсан судалгаа, 2001 он). 4. “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилт” судалгааны ажил (Монгол Улсын Засгийн газрын захиалга, 2007 он). 5. “Монгол Улсын хууль” төсөл, судалгааны ажил (**2 дэд төсөлтэй**, Монгол Улсын Засгийн газрын захиалга, 2008-2010 он). 6. “Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн эмхтгэл: Иргэний хэрэг” төсөл, судалгааны ажил (Хамтрагч байгууллага: УДШ, ХЗҮТ, ЖАЙКА, 2005-2008 он). 7. “Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн эмхтгэл: Эрүүгийн хэрэг” төсөл, судалгааны ажил (Хамтрагч байгууллага: УДШ, ХЗҮТ, АНУОУХА, 2006 он). 8. “Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн эмхтгэл: Захиргааны хэрэг” төсөл, судалгааны ажил (Хамтрагч байгууллага: УДШ,

		ХЗҮТ, Дэлхийн банк, 2005 он). 9. “Монгол Улсын дотоодын хууль Монгол Улсын хүний эрхийн олон улсын гэрээнд нийцэж буй байдалд шинжээчийн үнэлгээ өгөх” судалгаа (ХЭҮК-ийн захиалга, 2010 он). 10. “Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал” судалгааны ажил (ХЗДХЯ-ны захиалга, 2011 он). 11. “Монгол Улсын хүний эрхийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт” судалгааны ажил (ХЗДХЯ-ны захиалга, 2011 он). 12. “Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллага” дипломын ажил (1996 он, Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт). 13. “Терроризмтой тэмцэх зарим асуудал” магистрын ажил (2008 он). 14. Авилгын эсрэг конвенцтой Монгол Улсын хууль тогтоомжийг нийцүүлсэн талаархи эрх зүйн тойм судалгаа (АТГ-ын захиалга, 2014 он). **Долоо. БУСАД** 2002-2009 оны хооронд Хууль зүйн үндэсний төв /Одоогийн Хууль зүйн үндэсний хүрээлэн/-өөс эрхлэн гаргадаг 14 хоног тутмын **“Хууль зүйн мэдээ”** сониныг, 14 хоног тутмын **“Хууль зүйн мэдээлэл”** сэтгүүл, мөн улирал тутмын **“Хууль дээдлэх ёс”** сэтгүүлийг эрхлэн гаргах, түүнчлэн ном, гарын авлагыг давхардсан тоогоор 250 гаруй нэр төрлөөр, СД 27 нэр төрлөөр, **“Хуулийн цаг”** телевизийн нэвтрүүлгийн 83 цувралыг бүтээх, нийтэд түгээх, түүнчлэн эрх зүйн мэдээллийн сангийн **www.legalinfo.mn** цахим хуудсыг үүсгэн бий болгох, ажиллуулах, хөгжүүлэхэд Хууль зүйн мэдээллийн төвийн даргын эрхэлж байсан ажил, үүргийн хүрээнд зохион байгуулж, биечлэн оролцож, хяналт тавьж ажилласан болно.

Хүсэлт гаргасан: Д.БАЯНБИЛЭГ

2026 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр